



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭХЭМҮТ,
Аймгийн БОЭТ, Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн
болон тусгай мэргэшлийн эмнэлгийн
захирал, дарга нарт

Монгол Улсын засгийн газрын тухай хуулийн 24.2, яамны зорх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11; 7.1.13 дугаар заалтыг, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөр, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 338 дугаар тушаалын 2.4 дэх хэсэг, 2013 оны 344; 2013 оны 446 дугаар тушаалуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг. Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэд, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, онцлогт нийцсэн байдлаар үзүүлэхэд шаардлагатай ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэх сургалтыг нийт ажилчдыг хамруулан тогтмол явуулж тайлан мэдээг улирлаар гаргаж хэвших, үр дүнгийн гэрээ ба ажил дүгнэх үзүүлэлтэд харилцаа хандлагын алдаа зөрчилгүй ажилласан байдлыг оруулдаг болгох;

Хоёр. Эрүүл мэндийн байгууллагуудын гадна ба дотор хаяжилтыг өдөр ба шөнийн аль ч цагт иргэдэд ойлгомжтой болгох чиглэлээр:

Эрүүл мэндийн байгууллагыг тэр дундаа Яаралтай тусламжийн төв, хүлээн авах, төрөхийн хүлээн авахыг хоногийн аль ч цагт төвөггүйгээр олоход нь зориулсан хаяг, зураглал, лавлах, утасны дугаар зэргийг тодорхой байршуулах; Мөн хаягийг Монгол хэлээр, үгийн товчлолгүй гаргацтай бичих бөгөөд шөнийн цагаар гэрэлтүүлэгтэй, тодорхой харагдахуйцаар байрлуулах;

Гурав. Жирэмсний хяналтын ач холбогдлыг таниулах чиглэлээр:

1. Нөхөн үржихүйн насны болон жирэмсэн эмэгтэйчүүдэд жирэмсний хяналтад эрт орох нь эхийн болон хүүхдийн эрүүл мэндэд ямар ач холбогдолтой талаар, эсэн мэнд амаржихуйд эмэгтэй хүн өөрөө болон тэдний гэр бүлийнхэн, хамт олны зүгээс тавих анхаарал халамжийн талаар мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах;
2. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх арга барилд сургах мэдлэг

080053

сэргээх болон давтан сургалтуудыг тогтмол зохион байгуулж, үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх боломжоор ханган ажиллуулах;

3. Ямар ч эрүүл мэндийн байгууллагууд жирэмсэн эмэгтэйд хүндрэл учруулахгүй, оршин суугаа байршилд ойрхон, харъяалал харгалзахгүйгээр тусламжийг үзүүлэхээр зохион байгуулалтын арга хэмжээ авах

Жирэмсэн үйлчлүүлэгчийг угтаж, эрэмблэх тусламж үйлчилгээг зөв чирэгдэлгүй, шуурхай авахад нь туслах

Дөрөв. Албан далгаварын биелэлтийг тайлагнах чиглэлээр:

1. Албан даалгаварыг дотоод нөөцдөө тулгуурлан хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх, хэрэгжилтийн тайланг 2018 оны 12 дугаар сарын 28-ны дотор ЭМЯ-ны Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх.

2. 2019 оноос албан даалгаварын хэрэгжилтийн улирлын тайланг дараа улирлын ажлын эхний долоо хоногт багтаан тайлагнах

3. Албан даалгаварын биелэлтийг гарган удирдлагын зөвлөлд танилцуулах, дарга захирлын үр дүнгийн гэрээнд тусган ажиллахыг ЭМЯ-ны Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгасгай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ